



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/692

Булган сум

Г Ж.Ганболдтой гэрээ шууд байгуулан  
эрх олгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Иргэний хуулийн 343 дугаар зүйл, 344 дүгээр зүйл, 345 дугаар зүйл, 346 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXV/05 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.4 дахь заалтын хүрээнд Орон нутгийн тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр суралцах оюутнуудыг Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Шинхан их сургуульд суралцуулахад шаардлагатай шат дараалсан арга хэмжээг зохион байгуулах ажлыг Булган аймгийн Булган сумын иргэн Жаранживаагийн Ганболдтой хууль, журмын хүрээнд 5,000,000 (таван сая) төгрөгийн гэрээ байгуулж, хамтран зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т үүрэг болгосугай.

2. Дээрх арга хэмжээний санхүүжилтийг "Шинэ Ирээдүй" хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ